

ХУДАЛ МЭДҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

Б.Түвшинболд

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахмад

Товч агуулга: Энэхүү өгүүлэлээр худал мэдүүлэх гэмт хэргийн монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн түүхэн уламжлал, энэ гэмт хэргийн шинж, хуулийн хэрэглээнд тулгамдаж байгаа бэрхшээлийн талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилоо.

Abstract: Historical traditions, features, and legal application of the crime of perjury in the criminal laws of Mongolia

Түлхүүр үгс: Худал мэдүүлэх, түүхэн уламжлал, онцлог

Keywords: Perjury, Legal traditions and features

Оршил

Хуулийн зорилт бол Монгол Улсын, эх орны хөгжил, тогтвортой байдлыг хангах, нийгмийн олон талт харилцааг шударга зохицуулах, эрх тэгш байх эрх зүйн орчныг бий болгох явдал юм.

Орчин цагт Монгол Улс Дэлхийн олон улсын чиг хандлагыг даган хөгжиж, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хуулийн зүйлчлэл, эрх зүйн орчныг сайжруулах асуудал хөндөгдөж байна. Үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь гэрч, хохирогчгүйгээр бүрэн явагдах боломжгүй. Гэрч болон хохирогчийн байр сууринд тохиолдлоор тааралдсан хүн ер нь ямар ч иргэн байх боломжтой.

Аливаа гэмт хэрэг үйлдэгдсэнийг, гэмт хэрэгтний гэм бурууг нотлох баримт нотолгоо байх ёстой. Харин нотлох баримтын гол эх сурвалж нь мэдүүлэг, тэр тусмаа гэрч, хохирогчийн мэдүүлэг юм. Нийгэмд үйлдэгдсэн гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, хэргийн бодит үнэн болон гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг

хуулийн дагуу зөв явуулахад гэрч, хохирогчийн үнэн зөв мэдүүлэг чухал үүрэгтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдүүлгийн эзлэх байр суурь өндөр юм. Гэрч, хохирогчийн гэмт хэрэг болсон үйл явдлын талаар ярьж, хэлж байгаа үг болгон нотлох баримт болдог учир үнэн зөв мэдүүлэх нь үнэн зөв байдал, бүр цаашлаад энэ нийгэмд чухал шударга ёсыг тогтооход ач холбогдолтой. Харин зориуд худал мэдүүлэг өгөх нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бөгөөд тодорхой хэмжээний хор уршиг, сөрөг үр дагаврыг дагуулдаг юм. Тухайлбал:

- Гэм буруугүй хүнийг гэмт хэрэгт холбогдуулах;

- Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхолд ноцтойгоор халдах. Эрт дээр үеэс монголчууд бидний өвөг дээдэс: “нэр хугарахаар яс хугар” гэж нэр төрөө дээдлэн үздэг байсан;

- Бусдын үндсэн хуулиар олгогдсон эрхийг ноцтойгоор зөрчих;

- Нийгмийн үнэт зүйл болох шударга ёсыг алдагдуулах; гэх мэт

Цаашлаад худал мэдүүлэх гэмт хэргийн одоогийн эрх зүйн зохицуулалт болон тус гэмт хэргийн монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн түүхэн уламжлалыг судлахад тус өгүүллийн зорилго оршино.

Үндсэн хэсэг

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг”-ийн бүлгийг бүтцийн хувьд, уг бүлэгт хуульчлагдсан тодорхой гэмт хэргүүдийг бүхэлд нь авч үзвэл уг бүлэгт зөвхөн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг чиглэсэн, Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх гэх хэргүүд хуульчлагдсан байна.

Худал мэдүүлэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн хорин нэгдүгээр бүлгийн 21.2 дугаар зүйлд Худал мэдүүлэх гэмт хэргийн шинж хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар Гэрч, хохирогч мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд, эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж хуульчилсан.

Монголчууд төр, эрх зүйн 2220 гаруй жилийн түүхтэй бөгөөд энэ хугацаанд Монгол газар нутагт

засаглалын янз бүрийн хэлбэр, өөр хоорондоо угсаа гарлын нэгэн хэв маяг бүхий төрт ёсны залгамжлал шингэсэн 10 гаран улс оршин тогтнож байсан. Эдгээр улс нь өөрийн төв аппарат, цэргийн зохион байгуулалтын зэрэгцээ өөрсдийн гэсэн хэв маяг онцлог бүхий хууль цаазыг батлан мөрдүүлж хэрэгжүүлж байсан ажээ.

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжлийг хэд хэдэн үе шатанд хуваан авч үздэг бөгөөд тухайн үеийн хууль тогтоомжид худал мэдүүлэг өгөх гэмт хэргийг хуульчилж ирсэн юм. Монголын эртний улсуудын нийгэм төрийн байгуулал нь дотоод харилцан уялдаа бүхий бүхэл бүтэн тогтолцоо байсны хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг хянан шийдвэрлэх хууль цаазны тодорхой бодлого тухайн төрт улсуудад залгамж чанартайгаар хэрэгжиж байсан бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх бодлого нь цогц байдлаар илэрхийлэгдэж хэрэгжиж байгаагүй ч хууль цаазын хувьд заншлын болон бичмэл хуулийн хэлбэртэйгээр хатуу чанд ял оногдуулах байдлаар хэрэгжиж байсан. Тухайн түүхийн үечлэлийн үед гэрч худал мэдүүлэх өгөх, гэрчийн эрх, үүргийн талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ тэр бүр байгаагүй эсхүл сайтар судлагдаагүй байсан байна. Хамаг Монгол Улс XII зууны эхээр Хэрлэн, Онон, Туулын ай сав нутагт байгуулагджээ. Хамаг Монгол Улсад тусгай бичигдмэл хууль цааз байгаагүй, заншлын эрх зүй үйлчилж байжээ. Тухайлбал, “Нууц товчоо” хэмээх Монголын түүхийн сурвалж бүтээлд дурдсанаар Тэмүүжинг Таргудай Хирилтуг барьж улсдаа

аваачаад засаглан шийтгэж, айл бүрд нэжгээд хонуулан хэсүүлж явна. Хаатай Дармаалааг барин авчирч, хавтсан дөнгө өмсгөж Халдун ууланд явуулав зэргээр тэмдэглэсэн байдаг бөгөөд өс хонзон авах, дөнгө зүүлгэж айл хэсүүлэх, хорих, нэгжих, дээрэм хийх, хулгай хийх, хүн алах, ор босгох, ял халдаах гэх мэт эрүүгийн цаазад холбогдох зүйлүүд агуулагдаж байсан байна. Ял халдаах гэмт хэрэг нь худал ярих, худал мэдүүлэг өгөхтэй төстэй зүйл байсан байна.

Монголын дундад үеийн төр эрх зүй /XIII-XX зууны эхэн үе/-н хууль цаазаар худал мэдүүлэг өгөх талаар зохицуулж байсан уламжлал: Монголын төр хууль цаазын энэхүү үе нь Их Монгол Улс байгуулагдахаас Ардын хувьсгал ялах хүртэлх нийт найман зууны Монголын төр ёс, эрх зүйн түүхийн урт хугацааг хамардаг. Тиймээс олон зуун жилийн төрт ёсны бодлого, Монголын дундад зууны үеийн хамгийн гол хууль цааз, эрх зүйн хэм хэмжээ энэ үед үйлчилж байсан учраас судлаачид нэлээд анхаарал хандуулж судалсан байдаг. Төр, эрх зүйн түүхийн судлаач эрдэмтдийн үзэж буйгаар энэ хуралдайгаар Их Монгол Улсын хууль цаазын гол сурвалж бичиг Их Засаг хуулийг хэлэлцэн баталсан, өөрөөр хэлбэл мөн оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн гэж ихэнх түүхч эрдэмтэд үздэг бөгөөд Их Монгол Улсын анхны хуульчилсан эрх зүйн хэмжээг нэгдмэл байдлаар агуулсан гол түүхэн эх сурвалж бол “Их засаг хууль” юм. “Их засаг хууль”-д шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт

хэргийн талаар дурьдсан тодорхой зүйл байхгүй боловч Монголын түүх, хэл уран зохиолын дурсгал болох “Монголын нууц товчоо”-нд нэгдсэн Монгол улсын төрийн шүүх эрх мэдэл, шүүн таслах ажиллагааны талаар дурьдсан байдаг. Чингис хаан эрт дээр үеэс худал хэлсэн хүнийг тэвчдэггүй байсан ба хатуу шийтгэдэг байсан. Чингис хаан урьдын төр улсын хаадын адил шүүх эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн ба шүүн таслах хэргийг үнэн шударгаар шийтгэж байх тухай ихэд санаа тавьж байсан бөгөөд Улсын дээд заргач гэдэг албан тушаалыг бий болгож, улсын доторх аливаа хэрэг маргааныг Шихихутагаар шийдвэрлүүлэхээр болжээ.¹

В.А. Рязановский “Чингис хааны засаг хууль” нь худал хэлэх, хулгай хийх, завхайрлыг хориглодог бөгөөд ойр дотныхоо хүмүүсийг өөрийн бие мэт хайрлаж, гомдол доромжлол үл үзүүлэн, тэдгээрийг ор тас мартаха² гэсэн агуулга бүхий заалт байсан гэж бичсэн бол дээрхтэй утга нэг заалт буюу “Нэг нэгэндээ хайртай байж худал хэлэхгүй, хулгай хийхгүй, урваж болохгүй, өтгөс ядуусыг тэтгэж яв”³ гэсэн заалт хэд хэдэн эх сурвалжид байсан талаар доктор, профессор Ж.Болдбаатар бичжээ. Эндээс үзвэл “Их засаг хууль”-ийн гол үзэл санаа нь хүнлэг, энэрэнгүй ёсонд тулгуурласан, гэмт явдлыг жигших, тэдгээрийн үндсийг таслахад чиглэсэн нилээд дэвшилтэт зорилт бүхий байсан нь ажиглагдаж байна. Энд бичигдсэн “... худал хэлэх”, “худал хэлэхгүй” гэсэн зан үйлийн хориг тогтоож, зөрчсөн тохиолдолд хатуу шийтгэл

¹ А.Амар Монголын товч түүх. УБ., 1989, 175 дах тал

² В.А. Рязановский. Великая Яса Чингисхана

³ Ж.Болдбаатар, Л.Лүндэжанцан Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 74 дэх тал

оногдуулж байгаа нь бидний үзэж буйгаар хэдийгээр шууд нэрлэн заагаагүй боловч тухайн зан үйл нь “худал гэрчлэх” гэсэн хууль цаазын ойлголтод мөн хамаарч байсан байж болох талтай юм. “Их засаг хууль”-д “Хэрэв хоёр хүн хэрүүл зарга болсон гэж мэдээлж хэлбэл түүнд хөндлөнгөөс хэн ч гар хүрдэггүй. Эцэг эх нь хүртэл үр хүүхдийнхээ хэрүүл маргааныг хайхарч хамаардаггүй. Гэвч хорлогдогсод нь зарга хийж болно. Зарга хийсэн хойно нь түүнд гар хөдөлсөн байвал ял тулгана, мөн түүнчлэн санаатайгаар худал хэлбэл, худал гэрчилбэл алах ял оногдуулахаар заасан нь хохирогчийн гомдлоор хэрэг үүсгэх, гэрч, хохирогч үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй болохыг, хохирогчийг хамгаалах тухай хэм хэмжээ тогтоож байсны тодорхой илрэл юм.

“Их засаг хууль”-ийн дараах түүний агуулга, зарчмыг хадгалсан хууль эх сурвалжуудын нэг бол 1320 оны батлагдсан “Их Юань Улсын нэвтэрхий толь”, “Их Юань Улсын хууль цаазын бичиг” /1271 он/, “Ертөнцийг засах магад хууль” зэрэг юм. Монголын Их Юань гүрний үед шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн талаар нарийвчлан хуульчилсан хууль цааз, тодорхой хэм хэмжээ олдоогүй боловч энэ талаар зарим эрдэмтэн, судлаачдын бүтээлд дурьдсан байна: “худал мэдүүлэг өгсөн бол буруутгагдах хүнд ноогдох ёстой ялыг хүлээлгэдэг, гэм буруу тулгаж байгаа бол түүнийгээ нотлох ёстой, хэрэв худал ял тулгаж байгаа бол оногдуулах ялыг нь түүнд

ногдуулдаг” зэргийг дурьдаж болно.¹ Үүнээс харахад мэдүүлэг үнэн зөв байх ёстой болон орчин цагийн ойлголтоор нь санаатайгаар худал мэдүүлбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалттай агуулгын хувьд адил байна. Тухайн нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан эрх зүйн зохицуулалт хийж байжээ. “Их Юань Улсын нэвтэрхий хууль”-д худал мэдүүлэг өгөх гэмт хэрэгтэй төсөөтэй гэмт хэргийг хуульчилж өгсөн нь хулгай, худал хуурмаг явдлаар явах үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял зэм хүлээлгэдэг байжээ. Эдгээр хууль цаазын түүхэн сурвалж бичгүүдэд аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхэд гэрчийн мэдүүлэг үнэн зөв байхад онцгой анхаарч, тэдний аюулгүй байдлыг хангах, урамшуулах олон арга хэмжээ авч байжээ.

Худал мэдүүлэг өгөхтэй холбоотой нэгэн зүйл “Алтан хааны цаазын бичиг”-т дараах байдлаар тусгагдан хуульчлагдсан байна. Энэ нь худал гэрчилж хүнийг цаазлуулбаас хүн тоолон мориор торго² гэсэн хэм хэмжээтэй байсан бөгөөд эндээс хэрэг хянан шийдвэрлэхэд гэрчийн мэдүүлэг, түүний үнэн зөв байдлыг чухалчилж байсан гэдэг дүгнэлт хийж болох юм.

1926 оны Шүүх цаазын бичиг бол Үндэсний хувьсгалын жилүүдэд дагаж мөрдөж байсан анхны эрүүгийн хууль мөн. Тус Шүүх цаазын бичиг нь бол ЗХУ-ын эрүүгийн хуулийн үлгэр дууриаллаар зохиогдсон юм.

1926 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 8-24-р зүйлүүдэд тодорхой төрлийн гэмт

¹ Г.Гантөмөр Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг: УБ., 2005, 9 дэх тал

² Т.Алтангэрэл XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд. УБ., 1999, 39 дэх тал

хэргүүд, тэдгээрт хүлээлгэх ялын төрөл хэмжээг хуульчилсан бөгөөд Шүүн таслах явдалд тэрслэх нь гэсэн 12-р бүлэгт гэрч, хэлмэрч, бусад этгээдээс хуурамчаар мэдүүлэх /70-р зүйл/, худал мэдүүлэх, хэлмэрчлэхдээ бусдаас үнэ, хөлс авах, ашгийг хичээх /71-р зүйл/ эс үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцно гэж хуульчилж өгсөн байна.¹

70-р зүйл: Аливаа хэрэг дор гэрч ба хэлмэрч зэргийн хүмүүс албаны газар худал хуурамчаар мэдүүлэх аваас 1 жилээс 2 жил хүртэл гянданд хорино.

71-р зүйл: Дээрх зүйл дор дурьдсан гэрчийн зэрэг хүмүүс худал хуурмагаар мэдүүлэхдээ үнэ, хөлс авах зэргээр хувийн ашиг тусыг хичээсэн болох аваас 2-3 жил хүртэл гянданд хорино²

Тайлбарлах нь: Эцэг эх, үр хүүхэд, ах дүү, эр эмийн зэрэг ойр ураг төрлийн хүмүүн аливаа хэрэг дор холбогдсон нэгнээ хамгаалахыг хичээж худал хуурмагаар мэдүүлбээс ял үл хэлэлцэнэ.³

Тус цаазын бичигт хуульчилсан байдал нь илүү ойлгомжтой болж дэлгэрүүлж өгсөн нь тус зүйл заалтыг хэрэглэхэд илүү дөхөм болсон нь харагдаж байна. Оногдуулах ялын төрөлд торгох ял нэмэгдүүлсэн, санаатайгаар гэж зааж өгсөн нь обьектив тал нь шууд хэлбэртэй байгааг харуулж байгаа нь тухайн үеийн шинэлэг зүйл байж болох юм.

1934 оны Шүүх цаазны бичиг нь эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тус Шүүх цаазны

бичигт 1926, 1929 оны Шүүх цаазын бичгүүдтэй адил шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргүүдийг тусгайлан бүлэг болгон зааж өгсөнгүй, харин хувьсгалын эсрэгүү гэмт хэрэг захиргааны журмыг эсрэгүүцэх онц аюултай гэмт хэргийн болон албан тушаалын гэмт хэрэг гэсэн өөр өөр бүлгүүдэд хуульчлагдсан байдаг. Шүүх цаазын бичгийн тусгай ангийн Захиргааны журмыг эсрэгүүцэх онц аюултай гэмт хэрэг гэсэн II бүлэгт гэрч, эксперт мэдүүлэг өгөхөөс татгалзах зайлсхийх /76-р зүйл/, зориуд худал мэдүүлэг өгөх /77-р зүйл/ гэмт хэргүүдийг хуульчилжээ.

Зүйл 77. Шүүн таслах ба мөрдөн байцаах газруудад хэн нэгэн хүнээс зориуд худал хуурамчаар мэдүүлэх ба түүнчлэн хэргийг мөрдөн байцаах буюу шүүн таслахаас байцаан шийтгэх явдлыг гүйцэтгэхэд гэрч, эксперт буюу орчуулагч нараас зориуд худал хуурмагаар мэдүүлсэн бол 3 сар хүртэлх хугацаагаар хорих буюу мөн хугацааны дотор албадан ажил хийлгэх ял шийтгэвэл зохино.

Хэн нэг хүнийг хүнд гэмт хэрэгт холбогдуулахыг оролдож, эсхүл ашгийг хичээн зориуд худал хуурмагаар мэдүүлэх буюу өчиг мэдүүлэг гаргавал 1 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл

¹ Б.Баярсайхан, С.Жанцан Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). УБ., 2011, 48 дах тал

² Д.Адъяабазар Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/. УБ, 1998, 18 дах тал

³ Мөн тэнд 50 дахь тал

зохино¹ гэж хуульчилж өгсөн байна. Эксперт гэж субъектийг шинээр хуульчилж өгсөн нь ололттой тал болсон бөгөөд хүнд гэмт хэрэгт холбогдуулахыг оролдож, эсхүл ашгийг хичээн гэж хүндрүүлэх нөхцөлийг мөн зааж өгчээ. Албадан ажил хийлгэх ялыг шинээр хуульчилж өгсөн байна.

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль нь Монгол улсад социализмын үндэс суурийг тавих үед дагаж мөрдөгдөж байсан эрүүгийн эрх зүйн тулгуур эх сурвалж мөн. Гэхдээ өмнөх шүүх цаазын бичгүүдэд шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргүүдийг засаг захиргааны журмыг эсэргүүцсэн онц аюултай гэмт хэргийн бүлэгт хуульчилсан байна. Тухайлбал: Гэрч, эксперт, орчуулагч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх /112-р зүйл/, зориуд худал мэдүүлэг өгөх, зориуд худал мэдээлэх /113-р зүйл/ гэмт хэргийг заажээ.²

113-р зүйл. Шүүх таслах газар ба мөрдөн байцаалтын газар хэн нэгэн хүнээс зориуд хов худал мэдээлэл оруулах, мөн түүнчлэн мөрдөн байцаах буюу шүүх таслах газраас хэргийг байцаан шийтгэхэд гэрч, эксперт, орчуулагч нараас зориуд худал хуурмаг мэдүүлбэл нэгэн жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэх буюу 1000 төгрөг хүртэл торгож шийтгэвэл зохино.

Хэн нэгэн хүнийг хүнд гэмт хэрэгт холбогдуулахыг оролдох,

эсвэл хувийн ашгийг хичээж гэмт хэрэг үйлдсэний баримтыг хиймэл аргаар зохиож худал хуурмаг хов мэдээллийг оруулах буюу мэдүүлсэн байвал 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино ³ гэж хуульчилж өгсөн байна.

1961 оны Эрүүгийн хууль бол олон жилийн турш дагаж мөрдсөн бөгөөд гэмт явдалтай тэмцэх Эрүүгийн эрх зүйн үндсийг бүрдүүлж байсан хууль юм. Өмнөх хуулиас эл хуулийн ялгагдах онцлог шинж нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг хориглосон явдал юм. Тус хуулийн Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргүүд 8-р бүлгийн 147-р зүйлд хуульчлагдсан байна.

147-р зүйл. Худал гэрчлэх.

а. Хэрэг бүртгэхэд буюу урьдчилсан мөрдөн байцаалтад болон шүүхэд гэрчлэгч этгээд зориуд худал мэдүүлэг гаргах, шинжээч худал дүгнэлт хийх, түүнчлэн орчуулагч зориуд худал орчуулбал 2 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 1 жил 6 сар хүртэлх хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

б. Энэ гэмт хэргийг үйлдэхдээ хүнд гэмт хэрэгт холбогдуулсан буюу яллах баримт хуурамчаар зохиосон, эсхүл хүнд хор аюул учруулсан буюу шунахай зорилго агуулсан бол 6 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ ⁴ гэж хуульчилж өгсөн байна.

Эксперт гэдэг ойлголтыг шинжээч гэж тодруулж өгсөн ба орчуулагч гэж тус гэмт хэргийн шинэ

¹ Д.Адъяабазар Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/. УБ, 1998, 85 дахь тал

² Г.Гантөмөр Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг. УБ., 2005, 20 дахь тал

³ Д.Адъяабазар Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/. УБ., 1998, 127 дахь тал

⁴ Д.Адъяабазар Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/. УБ., 1998, 189 дэх тал

субъект нэмж өгсөн нь тухайн үед гадаадын иргэн гэмт хэрэг үйлдэх болсныг тодотгон өгсөн байна. Шинэ субъект нэмж өгсөн нь тухайн үеийн ололттой шинэлэг тал юм. Мөн хүнд гэмт хэрэгт холбогдуулсан буюу яллах баримт хуурамчаар зохиосон, эсхүл хүнд хор аюул учруулсан буюу шунахай зорилго агуулсан гэж хүндрүүлэх нөхцөлийг тодотгож өгсөн байна.

Дүгнэлт:

Түүхэн уламжлалаас харахад Монголын эртний улсуудын нийгэм төрийн байгуулал нь дотоод харилцан уялдаа бүхий бүхэл бүтэн тогтолцоо байсны хувьд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг хянан шийдвэрлэх хууль цаазын тодорхой бодлого тухайн төрт улсуудад залгамж чанартайгаар хэрэгжиж байсан бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх бодлого нь цогц байдлаар илэрхийлэгдэж хэрэгжиж байгаагүй ч хууль цаазын хувьд заншлын болон бичмэл хуулийн хэлбэртэйгээр хатуу чанд ял оногдуулах байдлаар хэрэгжиж байсан байна. Тухайн үед гэрч худал мэдүүлэг өгөх, гэрчийн эрх, үүргийн талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ тэр бүр байгаагүй, эсхүл сайтар судлагдаагүй байсан байна. Монгол улсын Эрүүгийн эрх зүйн бодлогод өнө эртнээс тухайн цаг үеийнхээ онцлогт чадмаг тохируулан, шударга үнэнийг эрхэмлэсэн, гэмтнийг гэсгээн цээрлүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх цэгцтэй бодлого баримталж ирсэн түүхэн уламжлалтайг онцлон дүгнэх нь зүйтэй.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг”-ийн бүлгийг бүтцийн хувьд, уг бүлэгт хуульчлагдсан тодорхой гэмт хэргүүдийг бүхэлд нь авч үзвэл уг бүлэгт зөвхөн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг чиглэсэн, Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх үйлдлүүдийг гэмт хэрэг үйлдсэн тооцохоор хуульчлагдсан байна

Ашигласан материал

1. А.Амар Монголын товч түүх. УБ., 1989 он
2. В.А. Рязановский. Великая Яса Чингисхана
3. Ж.Болдбаатар, Л.Лүндээжанцан Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он
4. Г.Гантөмөр Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг. УБ., 2005 он
5. Т.Алтангэрэл XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд. УБ., 1999 он
6. Б.Баярсайхан, С.Жанцан Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). УБ., 2011 он
7. Д.Адъяабазар Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/. УБ., 1998 он
8. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634> Эрүүгийн хууль 2015 он
9. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он